



CLASSES D'ACCUEIL DU CYCLE D'ORIENTATION

DGEO • Chemin de l'Echo 5A • 1213 Onex

Téléphone direct : 022/327.05.42
Téléphone réception : 022/327.04.00
Courriel : admissions.DGEO@etat.ge.ch

Зорилго

Франц хэлний суурь мэдлэгийг 12-15 насны шилжин ирж буй сурагчдад олгох (ба шаардлагатай тохиолдолд сургуульд сурах зохих түвшинд хүргэх) түүнчлэн насны ангилалаар 9,10,11-р ангийн хэлний бэлтгэл ангиудад хамруулна.

Байрлал

Хэлний бэлтгэл ангиуд нь бүрэн дунд боловсролын сургуулиудад тархан байрладаг. Боломжтой тохиолдолд хүүхдүүд аль болох гэртээгээ ойрхон сургуульд хамрагдана. Гэвч зарим үед нийтийн тээврийн хэрэгслээр амархан очиж болох арай хол сургуульд хуваарилагдана. Энэ тохиолдолд хүүхэд үндсэн ангид шилжин суралцах үедээ сурч буй сургууль, эсвэл гэртээ ойрхон сургуулийн аль нэгийг сонгон суралцах боломжтой.

Сургуулийн захиргаа болон эцэг эхийн харилцаа

Сургууль эцэг эхчүүдтэй тогтмол харилцаатай байх зорилгоор сургуулиас эцэг эхийн хурал зохион байгуулана. Мөн багш нартай чөлөөтэй уулзаж болохоос гадна тэд бас гэрээр очиж уулзах боломжтой. Сурагч, эцэг эхчүүдэд зориулж сургууль бүрт нийгмийн ажилтан мөн сэтгэл судлаач байдаг.

Сурагчдын тоо

Багш нарт сурагч бүрийн түвшинд тааруулах, түүнчлэн сурагч нэг бүртэй тулж ажиллах боломжоор хангахын тулд ангид дээд тал нь 12 сурагч байна.

Хичээлийн хуваарь

Хичээл даваа, мягмар, лхагва гаригт өглөөд, пүрэв, баасан гаригт үдээс хойш, өглөөд 7ц50м - 11ц40м, үдээс хойш 13ц30 - 16ц40 цаг хүртэл.

Хөтөлбөр

Хөтөлбөрт франц хэлний хичээлийг голчлон үзэхээс гадна дараах хичээлүүд орно үүнд: математик, орчинтой танилцах, биеийн тамир, англи хэл, монгол хэл түүнчлэн 9,10-р ангид герман хэл үзнэ.

Үнэлгээ

Сурагчдын үнэлгээг гаргаж байгаа дэвшлийг тодорхойлсон бичгээр хийнэ. Энэ нь аажимдаа уламжлалт дүнгийн системд шилжих ба 6 бол хамгийн сайн дүн юм.

Үргэлжлэх хугацаа

Суралцагчид үндсэн ангийн хичээлийг төвөггүй дагаж чадах хүртэлээ хэлний бэлтгэл ангид шаардлагатай хугацаагаараа сурна. Тиймээс үндсэн ангид хичээлийн жилийн аль ч үед шилжүүлж болох бөгөөд энэ нь хүн бүрт харилцан адилгүй байдаг. Үндсэн ангид шилжүүлэх шийдвэрийг багш нарын санал дээр үндэслэн сурагч, эцэг эхийн зөвшөөрөлтэйгээр сургуулийн захиргаа гаргана.

Үндсэн ангиудын хуваарилалт

Үндсэн ангид хуваарилахдаа сурагчийн чадварт тааруулан тохирох ангид оруулна. Бүрэн дунд боловсролын сургалт нь сурагчдад (ерөнхий боловсрол, эсвэл жэнэвийн коллеж) эсвэл мэргэжлийн сургууль (үүнд: гар урлал, дүрслэх урлаг, худалдааны мэргэжилтэн, хөдөө аж ахуйн техникч) зэрэг мэргэжилүүдэд бэлтгэн суралцах боломжийг олгоно.

Хичээл таслалт

Өвдсөн эсвэл осолд орсон үед: ангийн багш эсвэл сургуулийн нарийн бичгийн даргад утсаар аль болох эрт мэдэгдэнэ. Сурагч сургуульдаа эргэж ирэхдээ шалтгаанаа бичгээр тайлбарлана. Хэрвээ таслалт 3 аас дээш хоног үргэлжлэх тохиолдолд эмчийн магадлал хавсаргах хэрэгтэй.

Хэрвээ хичээлд ирэхгүйгээ урьдчилан мэдэж байгаа (жишээ нь: эмчид үзүүлэх, шинжилгээ өгөх) тохилдолд доод тал нь 10 хоногийн өмнө сургуулийн захиргаанд бичгээр мэдэгдэнэ.

Хэрэгтэй мэдээлэл

Материал

Сургалт үнэгүй бөгөөд сурагчид материалаар (ном, дэвтэр) хангагдана. Харин цүнх, харандаа эсвэл үзгээ өөрөө авч ирнэ. Биеийн тамирт подвалк, кет, болон банны алчуур авч ирэх хэрэгтэй.

Эрүүл мэндийн даатгал

Эрүүл мэндийн ба гэнэтийн ослын даатгал заавал шаардлагатай. Орлого багатай эцэг эхчүүд сургуулийн нийгмийн ажилтанд хандаж улсаас олгох хөнгөлөлтийн талаар мэдээлэл авах боломжтой.

Нийтийн тээвэр

Автобусны сарын билет хүүхдэд хөнгөлөлтэй үнээр байдаг. Энэ билетээр Жэнэв хотын нийтийн тээврийн бүх чиглэлт зөрчих боломжтой.

Эцэг эхийн сургалт

Эцэг эхчүүдэд зориулан франц хэлний курсууд хичээллэдэг. Нэмэлт мэдээллийг

эцэг эхийн сургалт хариуцсан нарийн бичгээс 022 327 05 30 утсаар, эсвэл ecoledeparents@etat.ge.ch майл хаягаар холбогдон авч болно.

Бага, дунд ангид бүртгүүлэх (боломжтой бол оршин суух эрх болон эрүүл мэндийн даатгалын бичгээ авч ирэх)

Бага анги (4-12 нас): гэрийнхээ ойролцоох бага сургуульд биеэр очиж бүртгүүлнэ. Шинэ сурагч бүртгэх ажиллагааг сургуулийн захиргаа хариуцна.

Дунд анги (15-19 нас): (ACCES II) буюу дунд боловсролын 2 – р шатны бүртгэлд- 022 388 12 60 утсаар цаг авч rue Rousseau 8, 1201 Жэнэв хаягаар ирж бүртгүүлнэ.